



*Нэгтгэж тайлагнасан:*

Эрүүл мэндийн газрын дарга  
(албан тушаал)

Тэмдэг

(огноо)

*Төсвийн шууд захирагч*

..... /Ч.Оюунаа/  
(гарын үсэг)

2023.01.10.

БАЙГУУЛЛАГЫН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

/ДОРНОД АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР/

2023.01.10.

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин (IY улирал)	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Хувь
Стратеги төлөвлөгөөний зорилго 1: Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хариу арга хэмжээний болон нөөцийн бэлэн байдлыг хангана.							
1.	Зорилт 1: “Ковид-19” халдварт цар тахлын үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хариу арга хэмжээний болон нөөцийн бэлэн байдлыг хангана.	Шаардлага тай хэмжээгээр	Нөөцийг бүрдүүлэхэд шийдвэрлэсэн хөрөнгийн хэмжээ  Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, халдвараас сэргийлэх арга хэмжээнд шийдвэрлүүлсэн хөрөнгийн хэмжээ	994.9 сая төгрөг	Шаардагд ах хэмжээгээр	Цар тахлын үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах хүрээнд сайн дурын ажилтнуудыг нэмэлтээр ажиллуулахад шаардлагатай урамшуулал болон иргэдэд орон нутгийн 6 хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран сургалт, сурталчилгаа хүргэх ажлыг зохион байгуулахад шаардлагатай зардлын тооцооллыг боловсруулж ЭМБайгууллагуудаас төсвийг шийдвэрлэн ажилласан.	
1.1.	“Ковид-19” халдварт цар тахлын үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хариу арга хэмжээний болон нөөцийн бэлэн байдлыг хангах тооцооллыг нөхцөл байдалд уялдуулан тухай	-	Нөөцийг бүрдүүлэхэд шаардлагатай хөрөнгийн хэмжээ Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ,	994.9 сая төгрөг	Шаардагд ах хэмжээгээр  Шаардагд ах	Цар тахлын үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах хүрээнд сайн дурын ажилтнуудыг нэмэлтээр ажиллуулахад шаардлагатай урамшуулал болон иргэдэд орон нутгийн 6 хэвлэл мэдээллийн байгууллагуудтай	100

	бүр хийнэ.		халдвараас сэргийлэх арга хэмжээнд шаардлагатай хөрөнгийн хэмжээ		хэмжээгээр	хамтран сургалт, сурталчилгаа хүргэх ажлыг зохион байгуулахад шаардлагатай зардлын тооцооллыг боловсруулж ЭМБайгууллагуудаас хөрөнгийг шийдвэрлэн ажилласан. ЭМЯ-аас Коронавируст халдвар /Ковид-19/-ын бэлэн байдлыг хангахад шаардлагатай 1083.3 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, нэг удаагийн хамгаалах хувцас хэрэгслийг хуваарилан олгосон.	
1.2.	Бэлэн байдлыг хангах болон нөөц бүрдүүлэхэд шаардлагатай хөрөнгийг аймаг, сумын онцгой комисс болон холбогдох дээд шатны байгууллагад танилцуулан шийдвэрлүүлнэ.	Шаардлага тай хэмжээгээр	Бэлэн байдлыг хангах болон нөөцийг бүрдүүлэхэд шийдвэрлүүлсэн хөрөнгийн хэмжээ	236.3 сая төгрөг	Шаардагд ах хэмжээгээр	ЭМЯ-аас Коронавируст халдвар /Ковид-19/-ын бэлэн байдлыг хангахад шаардлагатай 1083.3 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, нэг удаагийн хамгаалах хувцас хэрэгслийг хуваарилан олгосон.	100
2.	Зорилт 2: “Ковид-19” цар тахлын үед иргэн, аж ахуйн нэгжийг дэмжиж, эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангана.	Зохион байгуулалтын	“Ковид-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх ухуулга, нөлөөллийн ажилд хамтран ажилласан аж ахуйн нэгжийн тоо	57	80	“Ковид-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх ухуулга, нөлөөллийн ажлыг Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Хэрлэн сумын багийн ажлын алба, Боловсрол шинжлэх ухааны газруудын нийт 35 албан хаагчид хамтран хэрлэн сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон аж ахуй нэгж, орон нутгийн өмчийн 135 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд халдвар хамгааллын дэглэм сахиулах, урьдчилан сэргийлэх хяналтыг хийж, мэдээлэл, сурталчилгааны	

						зөвлөмжийг түгээн байршуулан ажилласан.	
2.1.	“Ковид-19” халдварт цар тахлын үед аж ахуй нэгж, хувирааа хөдөлмөр эрхлэгчдэд ажлын байраа хадгалах, орлоготой байх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангах, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг тасралтгүй зохион байгуулна.	Зохион байгуулалтын	Сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлын тоо	60	60	Хэрлэн сумын 11 багийн 144 хэсгийн ахлагч, улаан загалмайн хорооны 66 сайн дурын ажилтнуудтай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан, мэргэжил арга зүйгээр ханган, аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, иргэдэд мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулсан. Ковид-19 халдварын нэмэлт тунгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх 1 сарын аяны хүрээнд сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд 21 удаа 754 хүнд сургалт зохион байгуулж, 2039 иргэдэд мэдээлэл, сурталчилгааг хүргэсэн. Төр, нутгийн захиргааны болон орон нутгийн өмчит аж ахуй нэгж байгууллагуудад 3 удаа албан тоот хүргүүлж, хуваарийн дагуу давхардсан тоогоор 118 удаа сургалт, нөлөөллийн ажлыг хийж нийт 1447 ажилтан, албан хаагчдад хүрч үйлчилсэн.	100
			Мэдээлэл, сурталчилгаанд хамрагдсан хүний тоо	254242	254242	Коронавируст халдвар /COVID-19/- аас урьдчилан сэргийлэх чиглэлээр цахим хуудсанд давхардсан тоогоор 915 зөвлөмж байршуулсан, хандалт 45762, давхардсан тоогоор 3127 төрлийн, 18621 ширхэг гарын авлага, зөвлөмжийг иргэдэд түгээсэн. Тайлант онд мэдээлэл, сургалт, сурталчилгаанд хамрагдсан хүний	100

						тоо давхардсан тоогоор 279667 байна. <a href="https://www.dornod.moh.gov.mn">https://www.dornod.moh.gov.mn</a> <a href="https://www.facebook.com/dornodemgazar">https://www.facebook.com/dornodemgazar</a>	
2.2.	Цахим суваг ашиглан “Ковид-19” шинэ болон сэргэн тархаж буй халдвараас сэргийлэхэд салбар дундын хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.		Хамтран ажилласан байгууллагын тоо	4	5	“Ковид-19” шинэ болон сэргэн тархаж буй халдвараас сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор анхан шатны 13 сумын өрхийн эрүүл мэнд төв, 3 өрхийн эрүүл мэндийн төв, Цагдаагийн газар, Бүсийн төв Онцгой байдлын газар, ЗДТГ, Хэрлэн сумын ЗДТГ, Боловсрол шинжлэх ухааны газар, сургууль, цэцэрлэгүүдтэй хамтран 69 байгууллагын албаны ёсны цахим хуудас, фэйсбүүк, пэйж хуудсаар дамжуулан сургалт, нөлөөллийг зохион байгуулсан. Тайлант онд хамтран ажилласан байгууллагын тоо 78.	100
			Цахим сувгаар нэвтрүүлсэн мэдээллийн тоо	24350	Гүйцэтгэлээр	Коронавируст халдвар /COVID-19/-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр цахим хуудсанд давхардсан тоогоор 915 зөвлөмж байршуулсан, хандалт 45762, давхардсан тоогоор 3127 төрлийн, 18621 ширхэг гарын авлага, зөвлөмжийг иргэдэд түгээсэн. Тайлант онд цахим сувгаар нэвтрүүлсэн мэдээллийн тоо 25187 байна. <a href="https://www.dornod.moh.gov.mn">https://www.dornod.moh.gov.mn</a> <a href="https://www.facebook.com/dornodemgazar">https://www.facebook.com/dornodemgazar</a> <a href="https://www.dornod.moh.gov.mn">https://www.dornod.moh.gov.mn</a> <a href="https://www.facebook.com/dornodemgazar">https://www.facebook.com/dornodemgazar</a>	100

						zar <a href="https://www.facebook.com/DornodNEMT/">https://www.facebook.com/DornodNEMT/</a> <a href="https://www.facebook.com/nccdgov/videos/506266061007469">https://www.facebook.com/nccdgov/videos/506266061007469</a> @jaranmn @dornodtv @dornodTV6	
2.3	Сургууль, цэцэрлэгийн насны зорилтот бүлгийн хүүхдүүдийг улирлын томуугийн дархлаажуултад бүрэн хамруулна.	ОНХС 67.5 сая	Дархлаажуулалт ад хамрагдсан хүүхдийн тоо	2160	2000	Аймгийн Засаг даргын 2022 оны А/31 дүгээр захирамжаар батлагдсан төсөл арга хэмжээний хүрээнд зорилтот бүлгийн 2000 хүүхдийг томуугийн дархлаажуулалтад хамруулах худалдан авах ажиллагаа зарлаж, “Ди Жи Би” компани шалгарч гэрээ байгуулан улирлын томуугийн 2000 хүн/тун вакциныг нийлүүлсэн. Сум, өрхийн ЭМТөвүүдэд улирлын томуугийн вакциныг хуваарилж 2000 буюу зорилтот бүлгийн хүүхдүүдийг 100 хувь хамруулж, томуугийн хүндрэлээс урьдчилан сэргийлсэн байна.	100
Стратеги төлөвлөгөөний зорилго 2: Хүний хөгжлийн индексийн үзүүлэлтээр аймгуудаа тэргүүлэгч байр сууриа хадгалж хүн амын дундаж наслалт, амьдралын чанарыг нэмэгдүүлнэ.							

1.	Зорилт 1: Эрүүл мэндийн салбарт орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.		Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (промилль) Нялхсын эндэгдлийн түвшин (промилль)  Халдварт өвчний гаралт буурна. (10000 хүн амд)  Халдварт бус өвчний тохиолдол багасна. (10000 хүн амд)  Хүн амын дундаж наслалт нэмэгдэнэ.	9.8  7.5  2831.0  5309.3  69.69	9.0  7.0  2830.5  5302.3  70.1	Аймгийн хэмжээнд 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 19 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөд 12 промилль ногдож, өмнөх оны мөн үеэс 1.9 промилиор нэмэгдсэн Нялхсын эндэгдэл 13 тохиолдол бүртгэгдсэн нь 1000 амьд төрөлтөд 8,2 болж өнгөрсөн оны мөн үеэс 0,5 промилиор нэмэгдсэн байна.. Амьгүй төрөлтийн 9 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 6 тохиолдоор буурсан байна. Төрөлхийн хөгжлийн гажгийн 26 тохиолдол бүртгэгдээд байна. Халдварт өвчин 8503 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 1021.4 өвчлөл ногдож байгаа нь өмнөх оны мөн үеэс 2 дахин буурсан үзүүлэлттэй байна. Халдварт бус өвчлөл 77093 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 9260.4 өвчлөл ногдож 2 дахин нэмэгдсэн нь нийт хүн амын дунд эрт илүүлэг үзлэг хийсэнтэй холбоотой. Хүн амын дундаж наслалт 2021 оны байдлаар 70.23 болж өмнөх оныхоос 0.45 насаар нэмэгдсэн байна. Хүн амын дундаж наслалт 2021 оны байдлаар 70.23 болж өмнөх оныхоос 0.45 насаар нэмэгдсэн байна.	
1.1.		ОНТ 52.0 сая	БЗДХ-ын тохиолдлын тоо	132.2	132.1	Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээ"-ний хүрээнд "Бэлгийн замаар дамжих халдвар болон сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах" төсөл арга хэмжээг 60 сая төгрөгөөр	100

	“Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээ” БЗДХ-аас урьдчилан сэргийлэх тархалтыг бууруулах төсөл хэрэгжүүлнэ.					санхүүжүүлэн зорилтот бүлгийн 10000 иргэнийг үзлэгт хамруулахаар төлөвлөж ажилласан ба хамрагдалт 9700 буюу 97 хувь байна. Хэрлэн сумын эрсдэлт бүлгийн 900 гаруй иргэд, ЕБС-ийн 15-18 насны 1460 сурагч, ПТК, ДИС, МСҮТ-ийн 755 оюутан залуус, 10 төрийн байгууллагын 1000 гаруй албан хаагчид, Уул уурхайн 370 ажилчин албан хаагчид, 13 сумын зорилтот бүлгийн 600 иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулж, тэмбүүгийн 21, заг хүйтний 15, трихоминиаз 16, мөөгөнцрийн 30, шээсний сувгийн үрэвсэлт 10 өвчлөлийг илрүүлэн, 100 хувь эмчилгээнд хамруулсан. Хавьтлын илрүүлэлт 85.0 хавьтлын эмчилгээ 80 хувь байна. Бэлгийн замаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх 3 төрлийн сэдэвт сургалтыг төрийн болон орон нутгийн өмчит хувийн хэвшлийн 34 байгууллагын ажилтан, албан хаагч, оюутан сурагчид нийт 2585 иргэнд зохион байгуулсан. Тайлант хугацаанд тэмбүү өвчин өмнөх оны мөн үеэс 36, заг хүйтэн 8 тохиолдлоор буурч, трихоминиаз 161 тохиолдлоор нэмэгдсэн. БЗДХ-ын тохиолдлын тоо 122 болж өмнөх оны мөн үеэс 10.8 промилиор ихэссэн байна.	
1.2.	“Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга	Зохион байгуулалт		12.0	7.8 11.8	Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах зорилгоор	100



	хэмжээ” сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх тархалтыг бууруулах төсөл хэрэгжүүлнэ.	ын	Сүрьеэгийн тохиолдлын тоо			сүрьеэгийн хавьтлын болон эрт илрүүлэг үзлэгт нийт 3134 иргэнийг хамруулж, сэжигтэй 111 иргэнээс сорьц тээвэрлэн сүрьеэгийн 5 шинэ тохиолдлыг илрүүлэн эмчилгээнд хамруулсан. Тайлант онд сүрьеэ өвчний 56 тохиолдол шинээр бүртгэгдсэн нь 10 000 хүн амд 6.7 болж, өмнөх оны мөн үеэс 0.1 промилиор ихэссэн байна. "Сүрьеэ өвчин, түүнээс урьдчилан сэргийлэх" сэдвээр төрийн 15 байгууллага, аж ахуй нэгж, сургууль, цэцэрлэгийн 500 ажилтан, албан хаагч, хүүхдүүдэд сургалт зохион байгуулж, 1000 ширхэг гарын авлага түгээсэн.	
1.3.	“Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээ” Дархлаажуулалтын үйл ажиллагааг өргөжүүлж, томуугийн вакцинд хамруулна.	ОНТ 15 сая	Дархлаажуулалтын хувь	99,4	99.0 99.4	Дархлаажуулалтын үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор заавал хийх товллын 6 төрөл, тархвар судлалын заалтаар 5 төрөл, сайн дурын 2 төрлийн вакциныг татан авч иргэдийг дархлаажуулалтад хамруулсан байна. Үүнд: Заавал хийх товллын дархлаажуулалтын хамралт 98.8 хувь. Тархвар судлалын заалтаар хачигт энцефалитийн 800 хүн тун вакцин, тарваган тахлын 400 хүн тун вакциныг эрүүл мэндийн байгууллагын эмч, ажиллагсад, цагдаа, онцгой байдлын газрын мэргэжлийн албан хаагчид болон голомт бүс нутгийн хүн амыг дархлаажуулалтад хамруулсан. Зорилтот бүлгийн 31-40 насны эмэгтэйчүүдийн гепатит В вирусын 3	100

						тунгийн дархлаажуулалтад 982 эмэгтэй хамрагдсан. Томуугийн сайн дурын дархлаажуулалтад 100, зорилтот бүлгийн 2000 хүүхдүүд, тархвар судлалын заалтаар 1-12 насны-7171, жирэмсэн-270, архаг хууч өвчтэй-3927, эрүүл мэндийн байгууллагын ажилтан-812 иргэдэд хийгдэж 95.2 хувийн хамралттай байна. Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх дархлаажуулалтын 1 дүгээр тун 86.9, хоёрдугаар тун 83.6, гуравдугаар тунд 44.2, дөрөвдүгээр тун 9.5 хувийн хамралттай байна. 5-11 насны коронавируст халдвар (КОВИД-19)-ын дархлаажуулалтад 238 хүүхэд хамрагдсан.	
1.4.	Суурь өвчлөлтэй болон зорилтот бүлгийн хүүхдүүдийг зуны сувилалд хамруулах ажлыг үргэлжлүүлнэ.	ОНТ 30 сая	Сувилалд хамрагдсан хүүхдийн тоо	400	400	Суурь өвчлөлтэй зорилтот бүлгийн болон бага насны хүүхдүүдийн зуны сувиллыг 14 суманд ажиллуулах 2 багц бүхий ажлын даалгаврын дагуу 13 суманд сумын эрүүл мэндийн төвийг, Хэрлэн суманд “Их нандин групп” ХХК-ыг түшиглэн хоол тэжээлийн хурц болон архаг дутагдлаас үүдэлтэй сульдаа, жингийн алдагдал, цус багадалттай 400 хүүхдүүдийг зуны сувилалд 100 хувь хамруулснаар бага насны хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлтүүд 50 хувиар сайжирсан байна.	100
1.5	Сумын ахмадуудыг өдрийн сувилалд хамруулах	ОНТ 27 сая	Сувилалд хамрагдсан ахмадын тоо	810	810	Хөдөөгийн 13 сумын Эрүүл мэндийн төвийг болон орон нутаг дахь амралт сувиллын газрыг түшиглэсэн ахмад настны зуны сувилалд нийт 810	100

						<p>ахмад настанг /100хувь/ хамруулж сэргээн засах эмчилгээ, эрүүл хооллолт, эмийн эмчилгээ, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, дасгал хөдөлгөөнөөр эрүүлжүүлсэн. ОНТХ-ийн 27.0 сая төгрөгийн санхүүжилтээр 4 дэх жилдээ хэрэгжсэн сувиллын үр дүнд нийт ахмад настны 87.0 хувьд нь артерын даралт тогтмолжсон, 88.1 хувьд нь нойргүйдэл багассан, 86.0 хувьд нь эрхтэн сиситемийн хавсарсан зовиур болон өвдөлт багассан, сэтгэл зүйн байдал болон хөдөлгөөний идэвхид ахиц гарч эрүүл мэндийн боловсрол дээшилсэн, ахмад настанд чиглэсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн үр дүнтэй байна.</p>	
1.6.	Оюутны эрүүл мэндийг дэмжих "Эрүүл оюутан төсөл" хэрэгжүүлнэ.	ОНТ 20.0 сая	Үзлэгт хамрагдсан оюутны тоо	889	900	<p>Аймгийн Засаг даргын 2022 оны А/41 дүгээр захирамжийн дагуу Дорнод Их сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Политехник коллежийн 755 /86.8%/ оюутан залуусыг 6 төрлийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулж, үзлэгт давхардсан тоогоор 937 өвчлөл /Чих хамар хоолойн өвчлөл 200, нүдний өвчин 199, шүдний өвчлөл 495, бэлгийн замын дамжих халдвартай 21, сүрьеэгийн илрүүлгийн асуумжид гэр бүл болон ойрын хавьтлын өгүүлэмжтэй 12/ илэрсэн ба 65.5 хувийг нь шүдний өвчлөл эзэлж байна. Хувийн хэвшлийн Супердент, Family smile, БЭСУ, Гандент шүдний эмнэлгүүдтэй</p>	100

						18 сая төгрөгийн гэрээ байгуулан шүдний өвчлөлтэй 1, 2 дугаар дамжааны 200 оюутны амны хөндийг бүрэн эмчлэн эрүүлжүүлж, 702 оюутан залууст халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамрагдахын ач холбогдлын талаарх танхимын сургалт зохион байгуулж, 4 төрлийн сурталчилгааны материалыг 300 хувь хэвлүүлэн түгээж, 45 оюутанг “Оюутан сургагч багш”-аар бэлтгэсэн. Үзлэгт хамрагдсан оюутны тоо 937.	
1.7.	Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог шинэчилж, урьдчилан сэргийлэх, зонхилон тохиолдох өвчнийг эрт илрүүлэх, хариу арга хэмжээг чанартай, хүртээмжтэй зохион байгуулах, тандалт, эрт илрүүлгийн тогтолцоог бэхжүүлж, хүн амын дундаж наслалтыг 71-д хүргэнэ.	ОНТ	Дундаж наслалт  Эрт илрүүлгийн үзлэгт хамрагдагсдын хувь	69.69  74.0	70.1  85.0	ЭМС-ын 139 дүгээр тушаалаар “Хүн амын нас, хүйс, эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг”-ийн арга хэмжээний хүрээнд хамрагдвал зохих иргэдийн 55,8 хувийг хамруулахаар төлөвлөсөн бөгөөд тайлант хугацаанд 0-17 насны хүүхдийн 17060 буюу 54.1 хувь, 18-аас дээш насны иргэдийн 3331 буюу 21.1 хувь, 2022 онд хамрагдвал зохих иргэдийн 43.1 хувь хамрагдаад байна. Эрүүл мэндийн байгууллагуудын цахим хаягаар иргэдэд урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдахын ач холбогдол болон бусад мэдээллийг түгээн ажиллаж байна. Үзлэгт хамрагдсан иргэдийн хувь 43.1	100
1.8.	Зонхилон тохиолдох	-	Сургалт	5309	5302	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа	100

	халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй оролцоотой, нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулна.		сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо			явуулж байгаа 36 сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 25 эмч, 25 ерөнхий боловсролын сургуулийн 12 эмч нарт цахимаар 5 удаа, танхимаар 7 удаа сургалт хийж, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай мэдээлэл, эрт илрүүлэг үзлэгт хамрагдах тухай зэрэг мэдээллийг өгч ажилласан байна. мөн Хэрлэн сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Төрийн болон орон нутгийн өмчит аж, ахуйн нэгж, хувийн байгууллагуудад халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх 10 сэдвийн сургалтыг 70 байгууллагын 1500 ажилтан, албан хаагчдад мэдээлэл өгч, 1500 ширхэг гарын авлага түгээсэн. Халдварт бус өвчнөөс сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг хамрагдах тухай ТВ шторк, постёр контет мэдээллийг ЭМГ, НЭМТ, БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн фэйсбүүк, пэйж хуудас, албан ёсны сайтад байршуулан түгээж, ЭМГ-ийн цахим хуудас болон НЭМТ-ийн зөвлөгөө өгөх хуудсаар мэдээллийг түгээж 51 удаагийн мэдээллийг хандалт 37700, таалагдсан 24130, бусдад түгээсэн 870 байна. <a href="https://www.dornod.moh.gov.mn">https://www.dornod.moh.gov.mn</a> <a href="https://www.facebook.com/dornodemga zar">https://www.facebook.com/dornodemga zar</a>	
1.9.		ОНТ		0	2	Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 450.0 сая төгрөгийн хөрөнгө	100

	Хэрлэн сумын алслагдсан багт анхан шатны тусламж, үйлчилгээг ойртуулж, өрхийн эрүүл мэндийн төвийн салбарыг байгуулна.		Хэрлэн сумын алслагдсан багт шинээр байгуулагдсан өрхийн эрүүл мэндийн төвийн салбар			оруулалтаар хэрэгжих Өрхийн эрүүл мэндийн төвийн салбар эмнэлгийн барилгын ажлын гүйцэтгэгчээр Дорнын танан өргөө ХХК шалгарч барилгын ажил 2022 оны 5 сарын 22-д эхэлж 10 сард ашиглалтад хүлээн авсан. Мөн 131.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаад Хэрлэн сумын 5 дугаар багийн ажлын албаны байрны засвар, ӨЭМТөвийн өргөтгөл хийгдэж ашиглалтад орсон	
2	Зорилт 2: “Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр”-ийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлнэ.		“Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн хувь	80.0	81.0	“Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилт 94.0 хувь байгаа нь хэрэгжилтийн хувь ноднингийн мөн үеэс 14 хувиар нэмэгдсэн байна.	100
2.1.	Аз жаргал төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.	ОНХС 25,0 сая	Төвөөр үйлчлүүлсэн хүүхдийн тоо	2556	2600	Аймгийн Засаг даргын 2022 оны А/19 дугаар захирамжаар "Аз жаргал төв"-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн 25 сая төгрөгийн санхүүжилттэй төсөл арга хэмжээг баталж, төслийг хэрэгжүүлэхээр “Ашид батжин” ТББ шалгаран ажил гүйцэтгэх гэрээ байгуулан оюутан, залуучууд, өсвөр үеийн сурагчдад сургалт, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Аз жаргал төвөөр тайлант хугацаанд давхардсан тоогоор нийт 7068 хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлж, өмнөх оны мөн үеэс 536 хүүхдээр нэмэгдсэн байна. Шинээр 45 оюутан сургагч багшаар бэлтгэж, үе тэнгийн 262 сургагч багшийг чадавхжуулсан.	100

2.2.	“Эх хүүхэд, нөхөн үржихүйн арга хэмжээ” Эрүүл эмэгтэй төслийг хэрэгжүүлнэ.	ОНТ 15.0 сая	Төслийн хэрэгжилт	1000	50 70	Эрүүл эмэгтэй төслийн хүрээнд TORCH халдвар илрүүлэх шинжилгээний холбогдох оношлуурын нийлүүлэлтийг Илдэн гүн ХХК-аас хийгдсэн ба 2023 оны 1 дүгээр улиралд багтаан 200 эмэгтэйг шинжилгээнд хамруулна.	100
2.3.	“Эх хүүхэд, нөхөн үржихүйн арга хэмжээ”. “Эхчүүдээ хайрлая төслийг хэрэгжүүлнэ.	ОНТ 10.0 сая	Төсөлд хамрагдсан эхчүүдийн тоо	1000	1500	“Эхчүүдээ хайрлъя” төслийн хүрээнд нөхөн үржихүйн 31-40 насны 1000 эмэгтэйчүүдийг В вирусийн эсрэг 3 тунт дархлаажуулалтад 100 хувь хамруулсан	100
2.4.	Элэгний В вирусгүй нярай төслийг үргэлжлүүлж дархлал тогтоцыг үнэлэх ажлыг зохион байгуулна.	ОНТ 15.0 сая	Дархлаажуулалт ад хамрагдсан нярайн тоо	84	130	Элэгний “В” вирусийн халдвартай эхээс төрсөн 88 нярайд иммуноглобулин (НБИГ)-ээр дархлаажуулж, халдварыг таслан сэргийлэх ажлыг зохион байгуулсан.2022 оны эхний 12 сарын байдлаар 1578 эх амаржсан ба өнгөрсөн оны мөн үеэс 205 төрөлтөөр буурсан тул имунноглобулины үлдэгдэл нөөцтэй.	100
2.5.	“Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр”-өөр Өрхийн эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтнийг ажлын байрандаа чадваржиж, тогтвор суурьшилтай ажиллахад нь дэмжлэг үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	ОНТ 39.0 сая төг	Дэмжлэгт хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо	23	75	“Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутагт ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн тогтвор суурьшилтай ажиллах, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 39.0 сая төгрөгийг ОНТХ-өөс 13 сумын эрүүл мэндийн төвийн 78 сувилагчид тус бүр 500 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	100

						Тус арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж 2023 онд орон нутгийн төсвөөс 33 сая төгрөгийн дэмжлэг олгохоор шийдвэрлэгдээд байна.	
2.6.	“Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр”-ийн хүрээнд “Би сувилагч” ажил мэргэжлийн уралдаан, сумдын эрүүл мэндийн төвд ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтнийг ажлын байрандаа чадваржиж, тогтвор суурьшилтай ажиллахад нь дэмжлэг үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	ОНТ 89.0 сая	Уралдаанд оролцсон сувилагчийн эзлэх хувь	0	8	Тус онд орон нутагт анх удаа хэрэгжсэн ОНТХ-ийн 70.0 сая төгрөгийн санхүүжилт бүхий “БИ СУВИЛАГЧ” төсөлт уралдаан аймгийн Засаг даргын 2022 оны А/222 дугаар захирамжид заагдсан удирдамжийн дагуу 3 үе шаттай зохион байгуулагдаж, шалгарсан 3 сувилагчдад орон сууц худалдан авах байрны урьдчилгаанд тус бүр 20.0 сая төгрөгийн дэмжлэг, бусад 9 сувилагч нарт тус бүр 400.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон. Тус уралдаанд нийт 45 сувилагч оролцсон нь аймгийн эрүүл мэндийн салбарын нийт сувилагчдын 15 хувь нь хамрагдсан байна.	100
2.7.	Архи тамхины хэрэглээг хязгаарлах хяналтыг сайжруулах ажлыг эрчимжүүлэхэд хамтын ажиллагааг өрнүүлэх	-	Хамтран ажилласан байгууллагын тоо	1	5	“Шинэ үеийн залуучуудын сонголт архи биш” уриан дор аймгийн хэмжээнд аян зохион байгуулж, аяны хүрээнд төрийн 38 байгууллага, өсвөрийн үе тэнгийн сургагч 20 багш, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид нийт 3046 иргэнийг “Архины хор уршиг” сэдэвт сургалтад хамруулсан. Төрийн болон орон нутгийн өмчит 8 байгууллагатай хамтран “ШИНЭ ҮЕИЙН ЗАЛУУЧУУДЫН СОНГОЛТ АРХИ БИШ” архины хор уршиг, эрүүл мэнд, эдийн засагт үзүүлэх хор нөлөө, архинаас татгалзах сэдэл бүхий 8	100



					<p>төрлийн шторк боловсруулан олон нийтийн цахим сүлжээнд /<a href="https://www.facebook.com/dornodemgazar/videos/1806182132909850/">https://www.facebook.com/dornodemgazar/videos/1806182132909850/</a> байршуулан иргэдэд түгээсэн хандалт 7839, лайк 763, шейр 141 байна. Аймгийн Засаг даргын 2022 оны А/96 дугаар захирамжаар “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах” хөтөлбөрийн хүрээнд эрэгтэйчүүдэд үзүүлэх тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхээр 19 сая төгрөгийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэн, БОЭТ-ийн сэтгэцийн эрүүл мэндийн тасагт ганцаарчилсан зөвлөгөө өгөх өрөө, сургалтын кабинетыг тохижуулан эрэгтэйчүүдэд хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, зорилтот бүлгийн архины хамааралтай иргэдийг архинаас татгалзах, эрүүл зан үйлд суралцуулах сургалтыг зохион байгуулж, 3628 иргэнийг хамруулсан байна. Мөн төсөл хөтөлбөрийн хүрээнд архины хамаарлын шалтгаант сэтгэц зан үйлийн эмгэгийн стандарт эмчилгээнд 20 иргэнийг хамруулан, эдгэрэлт 100 хувь буюу дахилт өгсөн иргэн байхгүй байна. Сумын эрүүл мэндийн төвүүд Засаг даргын тамгын газруудтайгаа хамтран 16 иргэнийг архины шалтгаант сэтгэц зан үйлийн эмгэгийн эмчилгээнд хамруулан эрүүлжүүлсэн байна. Тайлант онд</p>
--	--	--	--	--	--

						хамтран ажилласан байгууллагын тоо 38, архинаас татгалзсан иргэдийн тоо 36.	
2.8.	Иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллах, амьдрах таатай орчин бүрдүүлсэн байгууллага, хамт олон, шалгаруулан сурталчлах	ОНХС 5,0 сая	Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоо	23	26	Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/472 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны А/22 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага” шалгаруулах орон нутгийн дэд комисс байгуулан, комисст хүсэлтээ өгсөн 7 байгууллагад үнэлгээ хийн 6 байгууллага болзлыг хангаж, эрүүл мэндийг дэмжигч байгууллагад шинээр 3, зэрэг ахиулсан 3 байгууллага шалгарч аймгийн хэмжээнд эрүүл мэндийг дэмжигч 26 байгууллагатай болсон байна. 2022 онд Хэрлэн сумын 9 дүгээр цэцэрлэг, Цагаан Овоо сумын цэцэрлэг, Булган сумын цэцэрлэг, Дашбалбар сумын эрүүл мэндийн төв, Баяндун сумын эрүүл мэндийн төв, мөн сумын Соёлын төв зэрэг байгууллагууд тус тус шалгарсан.	100
2.9.	Амьдарч буй орчноо эрүүл цэмцгэр ногоон байгууламжтай болгох хөдөлгөөн өрнүүлэх	-	Хөдөлгөөн өрнүүлсэн байгууллагын тоо	18	19	Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр эх орон, байгаль дэлхийгээ хайрладаг уламжлалт монгол зан заншлаа дээдэлж, хүн бүр байгалиа нөхөн сэргээх, хамгаалахад гар бие оролцох нөхцлийг бүрдүүлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор жил бүрийн 5, 10 дугаар сарын хоёр дахь долоо хоногийн "Бямба" гарагийг бүх нийтээр мод тарих үндэсний өдөр болгон зарлаж	100

						аймгийн хэмжээнд 5000 модны суулгац суулгасан. Тус өдрөөр ЭМГ, БОЭТ, анхан шатны эрүүл мэндийн нийт 19 байгууллагын хамт олон өөрийн байгууллагын орчин тойронд ногоон байгууламжаа сэргээн засварлаж, 100 гаруй ширхэг нарс, улиас болон 3-5 төрлийн 130 жимсний модыг шинээр тарьсан. Тайлант онд ногоон байгууламжтай болох хөдөлгөөн өрнүүлсэн эрүүл мэндийн байгууллагын байгууллагын тоо 19	
2.10.	Авгалдай, хортон шавьж устгалын үйл ажиллагааг тогтмолжуулах.	-	Хавар, намар хортон шавж, ариутгал, устгал хийсэн айл өрх, байгууллагын тоо	18	Өрхийн тоо 2550 Байгууллагын тоо 19	Ахуйн шавж, мэрэгч устгалын ажлыг зохион байгуулах, халдваргүйжүүлэлтийн уусмалыг зөв аргаар найруулах, хөрсөнд халдваргүйтэл хийх талаар зөвлөмж, мэдээллийг бүх шатны эрүүл мэндийн байгууллагад хүргүүлсэн. Авгалдай хортон шавж устгалын ажлыг дулааны улиралд зохион байгуулж, гэр хорооллын 2550 өрхийн 2550 нүхэн жорлон, 1350 муу усны цооногт халдваргүйтгэлийг давтамжтай хийж, үйл ажиллагааг зохион байгуулсан.	100
2.11.	Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжийг нэмэгдүүлэх	-	Шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжийн нэмэгдсэн тоо	1	2	Аймгийн Орон нутгийн хөгжлийн төсвийн 47.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сэргэлэн сумын эрүүл мэндийн төвийн боловсон ариун цэврийн байгууламжийг завсарлахаар төлөвлөгдөж аймгийн ОНӨГазраас 4 удаа худалдан авах ажиллагаа зарласан боловч санал ирүүлсэн оролцогч байгууллага	70

						гараагүй 2023 онд дамжин хэрэгжихээр төлөвлөөд байна.	
2.12.	Хүн амд эрүүл хооллолт, хоол тэжээлээс хамаарал бүхий өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг үе шаттай зохион байгуулах	-	Сургалтад хамрагдсан хүний тоо	3100	3600	Зонхилон тохиолдох халдварт бус өвчний анхдагч эрсдэлт хүчин зүйл болох зохисгүй хооллолтоос урьдчилан сэргийлэх эрүүл зөв зохистой хооллолтын сургалтыг төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 24 байгууллагын 747 албан хаагч, ажилчид, БОЭТ, өрх, сумын эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд давхардсан тоогоор нийт 59 удаа 3580 иргэнд тус тус зохион байгуулсан. Мөн олон нийтийн цахим сүлжээ, гэрээт телевизүүдээр эрүүл зөв зохистой хооллолт сэдвээр 10 удаагийн мэдээллийг тавьж, хандалт 1830, таалагдсан 910, бусдад түгээсэн 243 байна. НЭМҮТ-ээс “Монгол ногоо” төслийн хүрээнд аймгийн хэмжээний сургууль, цэцэрлэгийн эмч, хоол зүйч, тогооч нарыг хамруулсан цахим сургалтыг зохион байгуулж, нийт 20 хүүхдийн байгууллагын 86 мэргэжилтэн оролцлоо. Сургалтад хамрагдсан нийт хүний тоо 3666.	100
2.13.	Хүүхдийн байгууллагын хоол үйлдвэрлэл үйлчилгээний чанар, хүнсний аюулгүй байдалд хяналт үнэлгээг тогтмолжуулна.	-	Үнэлгээнд орсон байгууллагын тоо	37	37	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2022 оны 02 дугаар сарын 01/29 дугаар удирдамжийн дагуу аймгийн МХГ, БШУГ, ЭМГ-тай хамтран “Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн үдийн хоолны илчлэг, шимт бодисыг тодорхойлон, тогтоосон норм хэмжээ”-г хангаж буй	100

						эсэхэд хяналт үнэлгээ хийх, мэргэжил арга зүйн зөвлөгөөг 7 сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт цахимаар, Хэрлэн сумын ерөнхий боловсролын 12 сургууль, сургуулийн өмнөх боловсрол олгох 18 байгууллагад газар дээр нь очиж хяналт үнэлгээ хийсэн. Үнэлгээгээр гарсан зөрчил, дутагдал, дүгнэлтийг сургууль, цэцэрлэг тус бүрээр нь гаргаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжийн хамт хүргүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Үнэлгээнд орсон байгууллагын тоо 37.	
2.14.	Хувийн хамгаалах хувцас хэрэгслийг зайлшгүй хэрэглэх шаардлагатай, эрсдэл өндөртэй ажлын байранд хяналт хийх, мэдээлэл сургалт, сурталчилгаа зохион байгуулах	-	МСС-нд хамрагдсан ЭМБ-ын ажилтны хүний тоо	344	1000	Хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, зайлшгүй шаардлагатай, эрсдэл өндөртэй эрүүл мэндийн байгууллагуудад хяналт тавьж, Эрүүл мэндийн сайдын А/537 дугаар тушаалын 7 дугаар хавсралтын дагуу хувийн хамгаалах хувцас хэрэгсэл зөв өмсөж тайлах сургалтыг давхардсан тоогоор эрүүл мэнийн байгууллагын 1200 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд зохион байгуулсан нь өмнөх оны мөн үеэс 200 ажилтнаар нэмэгдсэн байна. ЭМС-ын А/36 дугаар тушаалын дагуу халдваргүйтгэлийн бодисыг зөв найруулах, хадгалах, хэрэглэхэд хяналт тавин ажиллаж байна.	100
2.15.	Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх Мэдээлэл сургалт,	-	Хамрагдсан иргэдийн тоо	15500	16600	Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх зорилгоор аймгийн	100

	<p>сурталчилгааг тасралтгүй, чанартай зохион байгуулна.</p>				<p>хэмжээнд 2022 оныг “Бүх нийтийн эрүүл мэндийн боловсрол-2022” зорилтот жил болгон зарлаж, 5 зорилт, 62 арга хэмжээний төлөвлөгөөг гарган, хэрэгжилт 92.5 хувьтай байна. Төлөвлөгөөний дагуу Хэрлэн сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Төрийн болон орон нутгийн өмчит аж, ахуйн нэгж, хувийн байгууллагуудад халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх 10 сэдвийн сургалтыг 70 байгууллагын 2563 ажилтан, албан хаагчдад мэдээлэл өгч, 5000 ширхэг гарын авлага түгээсэн.</p> <p>Халдварт бус өвчнөөс сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамрагдах тухай шторк, постер, контент мэдээллийг ЭМГ, НЭМТ, БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн фэйсбүүк, пэйж хуудас, албан ёсны сайтад байршуулан түгээж, нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийн 6 хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хүн амд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааг өдөр бүр үнэ төлбөргүй телевизээр нэвтрүүлэн мэдээллийг түгээн, хамтран ажиллаж байна.</p> <p>Аймгийн ЭМГ, НЭМТ-ийн зөвлөгөө өгөх цахим хуудсаар 415 удаагийн мэдээлэл зөвлөгөө байршуулж, хандалт 37700, таалагдсан 24130, бусдад түгээсэн 870 байна. Тайлант онд мэдээлэл, сургалт, сурталчилгаанд хамрагдсан иргэдийн</p>	
--	---	--	--	--	--	--

						тоо 24130	
2.16	Иргэдийн осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх мэдлэг хандлага дадлыг сайжруулах аян зохион байгуулах	-	Зохион байгуулсан аяны тоо	2	2	Иргэдийг осол гэмтэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Аюулгүй бай-Эрүүл бай” сэдэвт нэг сарын аян зохион байгуулж, “Осол гэмтэл ба архины хэрэглээ” сэдэвт сургалтад 2589 иргэнийг хамруулж, 8 төрлийн цахим мэдээллийг олон нийтийн сүлжээнд байршуулж иргэдэд түгээсэн. Монгол Улсын хэмжээнд “Зөвийг хэвшүүлье” уриан дор зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх “Сурагчийн аюулгүй байдалд эцэг, эх, асран хамгаалагчийн үүрэг, оролцоо” 1 сарын аяныг зохион байгуулан аяны хүрээнд нийт ЕБС-ийн 1800 сурагч, 1300 эцэг эх асран хамгаалагч, СӨБ-ийн 60 нийгмийн ажилтан, багш, ажилчдыг “Зөвийг хэвшүүлье” сэдэвт сургалтад хамруулсан. Зүүн бүсийн төв Онцгой байдлын газар, Цагдаагийн газраас зохион байгуулсан “Үер уснаас үрсээ хамгаалья” аянд нэгдэн хөдөлгөөнт эргүүлийг ажиллуулж, бага насны 45 хүүхэд, насанд хүрсэн 68 иргэнд зөвлөгөө, зөвлөмж өгч сэрэмжлүүлсэн.	100
2.17.	Хавдрын эсрэг хамтдаа аянг зохион байгуулж, хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлэх, иргэдийн мэдлэг хандлагыг дээшлүүлнэ.	-	Хамрагдсан иргэдийн тоо	17000	17000	Тайлант онд хавдрын өвчлөл 44 тохиолдол бүртгэгдэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 тохиолдлоор байна. Анхан шатны эрүүл мэндийн байгууллага бүрт хавдар өвчний эрт илрүүлэг үзлэг хийгдэж хэвшсэн бөгөөд үзлэгт хамрагдах бүх насны	100

					<p>иргэдийн 86 хувь нь хамрагдаад байна. Үүнд: Элэгний хавдрын эрт илрүүлэг шинжилгээнд 3164 иргэн хамрагдаж 124 өвчлөл, хөхний өмөнгийн үзлэгт 115685 иргэн буюу 96.2 хувь нь хамрагдаж, эмнэл зүйн эерэг 147 тохиолдол, умайн хүзүүний хавдрын илрүүлэгт 2808 иргэн буюу 47,5 хувь нь хамрагдаж пап шинжилгээ эерэг 377 тохиолдол бүртгэгдэж дараагийн шатны арга хэмжээг авч хяналтанд ороод байна. Мөн ЭМС-ын 139 дүгээр тушаалын дагуу эрт илрүүлэг хийгдэж, хамрагдвал зохих иргэдийн 43,1 хувь хамрагдаж хорт хавдрын тохиолдол 7 бүртгэгдээд байна. “Хавдрын эсрэг хамтдаа” аянаар 8451 иргэнд гарын авлага түгээж, ЭМГ болон сум, өрхийн ЭМТ-ийн цахим хуудсаар сурталчилгаа мэдээллийг нийтэлж нийт 1423 иргэн хандаж үзсэн байна. “Хавдаргүй ирээдүй өнөөдрөөс” уриатай Дорнод аймгаас Улаанбаатар хот хүртэл хэт холын зайн явган гүйлтийг БОЭТ-ийн сувилагч хийж, гүйлтийн спортоор дамжуулан иргэдэд эрүүл мэндийн зөвлөгөө мэдээлэл, хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, үзлэг шинжилгээнд хамрагдах тухай нөлөөлийн арга хэмжээг зохион байгуулж, нийт 1600 орчим иргэнд хүрсэн байна. Тайлангийн хугацаанд хавдрын илрүүлэг үзлэгт хамрагдсан иргэдийн тоо 22060 байгаа нь өмнөх</p>
--	--	--	--	--	--



						оны мөн үеэс 5060 иргэнээр нэмэгдсэн байна.	
2.19.	Байгууллагын үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр иргэдэд ил тод нээлттэй, түргэн шуурхай хүргэх	Үйл ажиллагааны зардал	Иргэдэд ил тод нээлттэй хүргэсэн мэдээллийн тоо	191	201	Эрүүл мэндийн газрын цахим хуудас dornod.moh.gov.mn болон байгууллагын фэйсбүүк хуудсанд эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын талаар мэдээ мэдээллийг тогтмол оруулж, шинэчлэн иргэдэд ил тод, нээлттэй мэдээлэн ажиллаж байна. Мөн нээлттэй ажлын байрны зарыг холбогдох хууль журамд заасны дагуу байршуулан ажилласан. Байгууллагын цахим хуудсанд нийт 252 мэдээ мэдээлэл оруулж, 6112 иргэнд хүргэсэн. Эрүүл мэндийн газар, Нийгмийн эрүүл мэндийн зөвлөгөө өгөх төвийн фэйсбүүк хуудсаар нийт 741 сэрэмжлүүлэг, зөвлөгөө тавьж давхардсан тоогоор 338360 иргэнд түгээсэн.	100
Стратеги төлөвлөгөөний зорилго 3: Эрүүл мэндийн байгууллагуудад гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлж, нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжүүлнэ.							
1.	Зорилт 1. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн аргыг эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлнэ.	ЭМДС, гүйцэтгэлээр	Санхүүжилтийн гүйцэтгэлийн хувь	100.0	100.0	БОЭТөв, УАУТөв нь тайлант хугацаанд 19,755.2 сая төгрөгийн санхүүжилт авч ажилласан бөгөөд гүйцэтгэл 91.7 хувь, анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд 7,623.5 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэл 92.8 хувь байна.	
1.1.	Тусламж үйлчилгээний чанар хүртээмж сайжирч	ЭМДС, гүйцэтгэлээр	Санхүүжилтийн гүйцэтгэлийн	100	100	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр	100

	гүйцэтгэлийн санхүүжилтийг төлөвлөсөн хэмжээнд авч ажиллана.		хувь	100	100	тогтоолын дагуу гүйцэтгэлээр санхүүжиж байгууллагууд болох БОЭТөв, УАУТөв нь тайлант хугацаанд 19,755.2 сая төгрөгийн санхүүжилт авч ажилласан бөгөөд БОЭТөв 91.9 хувь, УАУТөв 84.6 хувийн гүйцэтгэлтэй санхүүжилтийг авч ажилласан. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд гүйцэтгэлээр 7,623.5 сая төгрөгийн санхүүжилт авч 92.8 хувийн гүйцэтгэлтэй байна.	
2.	Зорилт 2. Нийгмийн цогц үйлчилгээний хүрээнд хөдөөгийн иргэдэд төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээг үзүүлэх		Үзлэгт хамрагдсан алслагдсан нутгийн иргэдийн хувь	10.0	10.0 20.0	Алслагдсан нутгийн болон отор нүүдэл хийж байгаа малчдад эрүүл мэнд, мал эмнэлэг, газрын харилцаа, жижиг дунд үйлдвэрлэл, хүүхэд хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, нийгмийн даатгал, улсын бүртгэл, соёл, ахуй үйлчилгээ, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулж, төрийн үйлчилгээг газар дээр нь хүргэх зорилгоор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 7/05 дугаар тогтоолоор батлагдсан сумдын хүн амд үйлчлэх “Нийгмийн цогц явуулын үйлчилгээ” төслийн арга хэмжээнд алслагдсан нутгийн 10766 иргэн хамрагдсан байна.	
2.1.	Алслагдсан нутгийн иргэдэд төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээг хүргэнэ.	ОНХС 36,0 сая	Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо	4000	8000	Алслагдсан нутгийн 7238 иргэдэд дотор, эмэгтэйчүүд, хэт авиа, хүүхэд, нүд, шүд, чих хамар хоолойн төрөлжсөн мэргэжлийн эмчид үзүүлсэн нь үзлэгт хамрагдсан иргэд өнгөрсөн оныхоос 81 хувиар өссөн байна.	100

						Мөн 7238 иргэнийг төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулснаас 87.4 хувьд нь өвчлөл илэрсэн. Үүнээс шинэ өвчлөл 19.3 хувийг эзэлж байна. Илэрсэн өвчлөлийн 80-аас дээш хувийг эмчлэн эрүүлжүүлсэн нь ноднингийн мөн үеэс 4.8 хувиар нэмэгдсэн байна. Алслагдсан нутгийн иргэдийн 20.6 хувь нь үзлэгт хамрагдсан.	
3.	Зорилт 3: Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, алслагдсан багийн иргэдэд эм зүйн тусламж, үйлчилгээг ойртуулна.		Алслагдсан багийн иргэдэд үйлчлэх эмийн сангийн тоо	3	4	Аймгийн төвөөс алслагдсан 2,8 дугаар багт үйл ажиллагаа эрхэлж байгаа Тун фарм, Батраш эмийн сангийн эрхлэгч нартай 2022 оны гэрээг шинэчлэн байгуулж, эхний хагас жилийн түрээсийн санхүүжилт олгох санхүүгийн баримт бичгийг бүрдүүлэн олгосон. Эмийн сангийн дотоод үйл ажиллагаанд стандартын хэрэгжилтийн дэмжлэгт хяналтыг 1 удаа хийж, коронавируст халдвар болон томуугийн өвчлөлтэй холбоотой шаардлагатай мэдээ тайланг тухай бүр авч, мэдээллээр ханган ажиллаж байна. Алслагдсан багийн иргэдэд үйлчлэх эмийн сангийн тоо хэрлэн сумын хэмжээнд 4 болсон байна.	
3.1.	Аймаг, сумын төвийн алслагдсан багуудад эмийн сан ажиллуулна.	ОНТ 13.2 сая	Алслагдсан багт байршилтай эмийн сангийн тоо	3	4	Аймгийн төвөөс алслагдсан Хэрлэн сумын 1 дүгээр багийн иргэдэд эм зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх Арвижих тан 2 дугаар зэрэглэлийн эмийн санг ажиллуулахаар зөвшөөрөл олгосон. Алслагдсан багийн 1, 2, 8-р багийн иргэдэд эм зүйн тусламж үзүүлэх 3	100

						эмийн сангийн байрны түрээсийн дэмжлэгийг орон нутгийн төсвөөс үзүүлж байна.	
3.2.	Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, иргэд олон нийтэд “Эмийн зохистой хэрэглээг” төлөвшүүлэх аяныг үе шаттай зохион байгуулна.	Зохион байгуулалтын ажил	Аянд хамрагдсан иргэдийн тоо	7500	9000	Аймаг, сумын төвд үйл ажиллагаа эрхэлж байгаа 9 эмийн сангийн пэйж хуудас, лед дэлгэцээр дамжуулан Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх зөвлөгөө мэдээллийг давхардсан тоогоор 8751 гаруй иргэдэд хүргэсэн. Олон улсын Ахмадын өдрийг тохиолдуулан Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын “Ахмадын өдрийн үйлчилгээ”-нд хамрагдаж буй хөдөөгийн 13 сум, Хэрлэн сумын 11 багийн нийт 200 ахмадуудад ахмад настанд чиглэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх журам болон эмийн шинэчилсэн жагсаалтын талаар мэдээлэл хүргэж ажиллалаа. Тус үйл ажиллагаанд “Монос Дорнод” эмийн сантай хамтран эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, “Эмийг зөв хэрэглэх 5 алхам”-ын талаар нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж, артерын даралт хэмжиж амин дэм, гарын авлага түгээсэн. 10 дугаар багийн Ахмадын зөвлөлийн нэрэмжит “Асран хамгаалагч таны гавьяа” өдөрлөгт оролцож буй байнгийн асаргаа сувилгаа шаардлагатай ахмад настнуудыг асаргаа сувилгаа шаардлагатай ахмад настнуудыг асарч буй 50 гаруй	100

						асран хамгаалагч нарт "Буйр эм тан" эмийн сангийн жор баригч "Ахмад настны эмийн зохистой хэрэглээ" сэдэвт мэдээллийг хүргэн, зөвлөгөө өгч, нийгмийн хариуцлагын хүрээнд амин дэмийн багцаар хангаж ажилласан. Аянд хамрагдсан иргэдийн тоо 9001.	
4.	Зорилт 4: Эрүүл мэндийн салбарын ажилтан албан хаагчдын нийгмийн хамгааллыг дэмжин, нэн шаардлагатай мэргэжлээр эмнэлгийн мэргэжилтнийг бэлтгэн чадавхжуулна.		"Төрийн албан хаагчийн сургалт хөгжил, нийгмийн баталгааг дэмжих" хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь  Нэн шаардлагатай мэргэжлээр шинээр бэлтгэгдсэн мэргэжилтний тоо	90.0  30	90.0  32	Салбарын ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих арга хэмжээний хүрээнд амьдрах орон байраар ханган хөдөө орон нутагт ажиллаж 11 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг төрийн албан хаагчийн байранд, 14 ажилтныг эмч, ажилчдын байранд амьдруулж байна. Тайлант онд 77.3 сая төгрөгийг эмнэлгийн ажиллагсдын амьдрах сууцаар хангах, орон байр, хашааны засварт дэмжлэг үзүүлэхэд зарцуулжээ. "Төрийн албан хаагчийн сургалт хөгжил, нийгмийн баталгааг дэмжих" хөтөлбөрийн хэрэгжилт 93.6 хувь. Нэн шаардлагатай мэргэжлээр шинээр бэлтгэгдсэн болон одоо бэлтгэгдэж байгаа эмч, мэргэжилтний тоо 33.	
4.1.	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлтэд суурилсан нэн шаардлагатай эмч мэргэжилтнээр үе шаттай хангана.	УТ	Шинээр бэлтгэгдсэн эмч, мэргэжилтний тоо	30	32	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлтэд суурилсан нэн шаардлагатай мэргэжлээр төрөлжсөн, мэргэжил дээшлүүлэх сургалтад БОЭТ, УАУТ, сумын эрүүл мэндийн төвийн 33 эмч, эмнэлгийн мэргэжилтэн нэн шаардлагатай мэргэжлээр шинээр бэлтгэгдэн	100

						суралцаж байна.	
4.2.	Эрүүл мэндийн салбарын ажилчдыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх багцын үзлэгт хамруулж, эмчилэн эрүүлжүүлнэ.	ЭМДС	Үзлэгт хамрагдсан эмнэлгийн ажилчдын тоо	935	941	Тайлангийн хугацаанд 18 эрүүл мэндийн байгууллагуудын 950 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг 7 төрлийн төрөлжсөн мэргэжлийн эмчийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрууллаа. Өвчлөл илэрсэн 48 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг дараагийн шатлалын тусламж, үйлчилгээнд хамруулж, 11.2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	100
4.3.	Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хөгжүүлэх “Эмч хөгжлийн төв” байгуулна	ОНХС 35.0 сая	Хөгжлийн төвийн тоо	0	1	Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвүүдийн дэргэд “Эмч хөгжлийн төв”-ийг орон нутгийн хөгжлийн сангийн 34.8 сая төгрөгийн хөрөнгөөр 9 нэр төрлийн 36 ширхэг тоног төхөөрөмж, тавилга эд хогшил нийлүүлэгдсэн. Үр дүнд нь тус “Эмч хөгжлийн төв”-үүдэд салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд ажлын байрандаа сурч боловсрох таатай орчин нөхцөл бүрдсэн.	100
4.4.	“Төрийн албан хаагчийн сургалт хөгжил, нийгмийн баталгааг дэмжих” дэд хөтөлбөрийг байгууллагын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, үр дүнг тооцох.	УТ, үйл ажиллагааны зардал	Төлөвлөгөөний хэрэгжилт хувиар	88.0	90.0	“Төрийн албан хаагчийн сургалт хөгжил, нийгмийн баталгааг дэмжих” дэд хөтөлбөрийг байгууллагын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж хийсэн ажлын тайланг дээд шатны байгууллагад тогтмол илгээн ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 2022 оны жилийн эцсийн байдлаар 93.6 хувь.	100
Стратеги төлөвлөгөөний зорилго 4: Эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай тусламж үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.							

1.1.	Зорилт 1: Эрүүл мэндийн байгууллагуудад нэн шаардлагатай барилгын засвар, шинэчлэл, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж чанартай, хүртээмжтэй тусламж үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.	УТ, ОНТ, ОНХС 5,121,1	- Шинээр ашиглалтад орсон эрүүл мэндийн байгууллагын тоо	0	5	Тайлант онд Баянтүмэн сумын ЭМТөв, НЭМТөв, Хэрлэн сумын 5 багийн ӨЭМТөвийн өргөтгөл, 2, 3-р багийн ӨЭМТөвийн салбарын шинэ барилгууд ашиглалтад орж улсын комисс байнгын ашиглалтад хүлээн авч, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх таатай орчин нөхцөл бүрдээд байна. Мөн шинээр баригдаж эхлэх 2022-2023 онд хэрэгжих Булган сумын ЭМТөвийн эхийн амрах байрны барилгын ажил эхэлсэн.	
			- Засвар хийгдсэн эрүүл мэндийн байгууллагын тоо	3	5	Аймгийн ОНТ, ОНХСангийн 442.8 сая төгрөгөөр 5 сумын эрүүл мэндийн төвд засвар хийгдэхээр төлөвлөгдсөнөөс Чойбалсан, Хөлөнбуйр, Баяндун, Чулуунхороот СЭМТөвүүдийн засварын ажил бүрэн дуусч ашиглалтад хүлээн авсан. Сэргэлэн сумын ЭМТөвийн ариун цэврийн байгууламжийн засварын ажлын худалдан авах ажиллагаа 4 удаа зохион байгуулагдаж санал ирүүлсэн оролцогч байхгүй шалтгаанаар амжилтгүй болж 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.	100
			- Автомашинаар хангагдсан эрүүл мэндийн байгууллагын тоо,	4	2, 3	- Аймгийн Гурванзагал, Сэргэлэн сум, Асралт-Үйлс өрхийн эрүүл мэндийн төвүүдийн түргэн тусламжийн автомашиныг 2022 онд аймгийн ОНТөсвийн хөрөнгө оруулалтаар шинэчлэхээр төлөвлөж худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж байсан боловч "Төрийн хэмнэлтийн тухай" хуулийн дагуу төрийн	100
			- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь	85	86.0		100

						байгууллагуудын хориглох заалтаар нөөцөд бүртгэгдэж буй автомашинаас шийдвэрлэхээр төлөвлөөд байна. -Эрүүл мэндийн болон боловсролын 66 байгууллагуудад аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 321.3 сая төгрөгийн хөрнгө оруулалтаар шаардлагатай тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл 100 хувь нийлүүлэгдсэн.	
1.2.	Хүүхдийн эмнэлгийн шинэ барилга барих ажлыг эхлүүлнэ.	УТ 3,400,0	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	40	70	Хүүхдийн эмнэлгийн барилгын ажил 4 дүгээр сараас эхлэн үргэлжилж байна.	100
			Барилгын инженерийн шугам сүлжээ, дотоод засалын гүйцэтгэлийн хувь	0	40	Тус эмнэлгийн барилгын инженерийн шугам сүлжээ, дотоод засалын ажлын худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж Гүйцэтгэгчээр Ихбазар констракшн шалгарсан. Барилгын гүйцэтгэлийн ажил 2021 онд 2.1 тэрбум төгрөгөөр А блокын 4 давхар хүртлэх карказын ажил, 2022 В блокын суурийн ажил, А блокын дээврийн караказын ил, Б блокын 1-р давхрын карказын ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн. Мөн барилгын гадна шугам сүлжээний ажилд 50.0 сая төгрөгийн гүйцэтгэл авч ажилласан болно.	
1.3.	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн шинэ барилга болон салбар эмнэлгийг ашиглалтад оруулна.	ОНТ 99,3 ОНХС 679,2	Шинэ барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	0, 0	100	Тайлант оны 12 сарын байдлаар Баянтүмэн сумын ЭМТөв, НЭМТөв, Хэрлэн сумын 5 багийн ӨЭМТөвийн өргөтгөл, 2, 3-р багийн ӨЭМТөвийн салбарын шинэ барилгууд	100
			Шинээр ашиглалтад орсон	0	5	ашиглалтад орж улсын комисс байнгын ашиглалтад хүлээн авч,	



			эрүүл мэндийн байгууллагын тоо			эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх таатай орчин нөхцөл бүрдээд байна. Мөн шинээр баригдаж эхлэх 2022-2023 онд хэрэгжих Булган сумын ЭМТөвийн эхийн амрах байрны барилгын ажил эхэлсэн.	
1.4.	Эрүүл мэндийн байгууллагуудын барилгад засвар хийнэ.	УТ 100.0, ОНХС 395.3	Засварын ажлын гүйцэтгэлийн хувь	3	100	- Аймгийн ОНТ, ОНХСангийн 442.8 сая төгрөгөөр 5 сумын эрүүл мэндийн төвд засвар хийгдэхээр төлөвлөгдсөнөөс Чойбалсан, Хөлөнбуйр, Баяндун, Чулуунхороот СЭМТөвүүдийн засварын ажил бүрэн дуусч ашиглалтад хүлээн авсан. Сэргэлэн сумын ЭМТөвийн ариун цэврийн байгууламжийн засварын ажлын худалдан авах ажиллагаа 4 удаа зохион байгуулагдаж санал ирүүлсэн оролцогч байхгүй шалтгаанаар амжилтгүй болж 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.	100
			Засвар хийгдсэн эрүүл мэндийн байгууллагын тоо	0	5		
1.5.	Эрүүл мэндийн байгууллагуудыг автомашинаар хангана.	ОНТ 126.0	Автомашинаар хангагдсан эрүүл мэндийн байгууллагын тоо	4	3	- Аймгийн Гурванзагал, Сэргэлэн сум, Асралт-Үйлс өрхийн эрүүл мэндийн төвүүдийн түргэн тусламжийн автомашиныг 2022 онд аймгийн ОНТөсвийн хөрөнгө оруулалтаар шинэчлэхээр төлөвлөж худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж байсан боловч "Төрийн хэмнэлтийн тухай" хуулийн дагуу төрийн байгууллагуудын хязгаарлах заалтаар нөөцөд бүртгэгдэж буй автомашинаас шийдвэрлэгдсэн.	100
1.6.	Эрүүл мэндийн байгууллагуудыг шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжөөр	ОНХС 321.3	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь	85	88.0	Тайлант онд эрүүл мэндийн болон боловсролын 66 байгууллагуудад аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 321.3 сая төгрөгийн хөрнгө	100

	хангана.					оруулалтаар шаардлагатай тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл 100 хувь нийлүүлэгдсэн.	
НИЙТ ХЭРЭГЖИЛТ							99.4

### ДҮГНЭЛТ:

Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилт бүхий 50 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллсан, төлөвлөгөөний хэрэгжилт 97.0 хувь.

- Үр дүнтэй буюу 100 хувь хэрэгжсэн үйл ажиллагаа 49
- Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70 хувь хэрэгжсэн үйл ажиллагаа 1, үүнд:
  1. Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжийг нэмэгдүүлэх

Тайлант онд аймгийн Эрүүл мэндийн байгууллагуудад Орон нутгийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 29 төсөл арга хэмжээг нийт 2.145,0 сая төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн.

Аймгийн Эрүүл мэндийн салбарын хэмжээнд Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Уламжлалт анагаах ухааны төв, сумын эрүүл мэндийн төв 13, өрхийн эрүүл мэндийн төв 3, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага 80, нийт 99 байгууллагад их эмч 202, сувилагч 300, эмнэлгийн бусад 299 мэргэжилтэнтэйгээр Дорнод аймгийн 84575 хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж ажилласан.